



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар A/164

Эг

**Чонын үргээлгэ зохион байгуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5, 28.1, 35.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Норовлин багийн нутаг Бархын нуруу, Улиасан даваа, Цэрэндоржийн даваа, Хүрэн өндөр, Шуудан даваа, Батширээт овоо зэрэг газруудад чонын тоо толгой олширч, мал болон малчны хот руу удаа дараа халдаж хорогдол учруулж байгаа тул 2024 оны 12 дугаар сарын 20-25-ны өдрийг дуустал хугацаанд чонын үргээлгэ зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Үргээлгэнд иргэд, малчдыг идэвх, зохион байгуулалт сайтай хамруулан оролцуулж, Галт зэвсэгтэй аюулгүй харьцах талаар заавар зөвлөгөө өгч ажиллахыг Норовлин багийн Засаг дарга (Б.Бадамгарав)-д үүрэг болгосугай.

3. Үргээлгийг зохион байгуулах явцад чоноос бусад ан амьтан авлахгүй байх ба чоно авласан тохиолдолд Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны Хяналтын улсын байцаагчид мэдэгдэж, зөвшөөрлийн бичгийг хуулийн дагуу авахыг анчдад сонордуулсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

232401335